

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төв, Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгтэй хамтран “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 25 дахь дугаараа бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн энэ дугаарын **“Судалгаа”** хэсэгт ТОП-20 индексийн өгөөжийн хэлбэлзэл, валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөг үнэлсэн үнэлгээг танилцуулж байна. Мэдлэгт суурилсан эдийн засагт амжилттай шилжсэн улс орнуудын жишээ болон өөрийн орны нөхцөл байдлыг харьцуулан дүгнэсэн баримтын судалгааны үр дүнг Монголын эдийн засаг мэдлэгт суурилах нь судалгааны ажлаас олж уншаарай. Түүнчлэн, Монгол ажиллагчдын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлагын харьцуулсан судалгаа, шинжилгээний ажлаас гарсан үр дүн, санал зөвлөмжийг танилцуулж байна.

“Үзэл бодол” хэсэгт ядуурал, эмзэг байдлын онол, арга зүй, судалгааны чиг хандлагат гарч буй өөрчлөлтийн талаар судлаач арга зүйн тойм үнэлгээ хийж, үр дүнгээ хэлэлцүүлж байна. Ядуу хүн амын бүлгийн тооцооллын талаарх судлаачын байр суурьтай танилцаарай.

“Сургалт” хэсгээс “Ядуурал тооцох арга зүйн асуудал” сэдвийн хүрээнд эдийн засгийн хэмжигдэхүүнүүдийг ашиглан ядуурлыг хэрхэн тодорхойлж байгаа талаар мэдлэгийн хүрээгээ тэлээрэй. Монгол улсад ядуурлын түвшинг тооцож буй арга аргачлалыг жишээгээр тайлбарлаж, ядуурлын үзүүлэлтүүдийг судалгаа шинжилгээ, хөгжлийн бодлого хөтөлбөр боловсруулахад ашиглах өргөн боломжийг энэхүү сургалтын хэсгээс олж аваарай. Хүн амын мэдээллийн чанарыг үнэлэх арга зүйн зарим асуудал сэдвээс хүн ам зүйн мэдээлэл тэр дундаа нас баралтын мэдээллийн чанар, алдааг үнэлж, тэдгээрийг шулуутган засварлах техникүүдийн талаар дэлгэрэнгүй танилцах боломжтой.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон уг сэтгүүлийн энэ дугаарыг бэлтгэн хэвлэхэд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монгол Улсын Их Сургуульд сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ